

Өндөр хэмийн ажлын өмнө “шатамхай хийн зөвшөөрөгдөх доод хэмжээ”-г шалгах тестийг хаана хийх вэ?

2020 оны 08-р сар



Өндөр хэмийн ажлын өмнө болон явцад “шатамхай хийн зөвшөөрөгдөх доод хэмжээ”-г шалгах цэгүүд

Сүүлийн жилүүдэд Өндөр Хэмийн Ажлын үед үсэрсэн очноос үүдэлтэй олон тооны гал түймэр, дэлбэрэлт гарсан. Ийм төрлийн ослын ноцтой үр дагаврын талаар 2020 оны 05-р сарын “Beacon”-нд дурдаж байсан. Өндөр Хэмийн Ажилд бэлтгэх үед мөрддөг нэг алхам бол “35 фут (10.7м)-ын зай дотор” шатамхай материал, ноцомхой уур байгаа эсэхийг шалгаж, сэргийлэх арга хэмжээ юм.

(*АНУ-ын ХАБЭА ба Гал Хамгаалах Үндэсний Холбооны зөвлөмж).

Олон байгууллага өндөр хэмийн ажлын явцад оч үсэрч болзошгүй бүх хэсэгт шатамхай уур байгаа эсэхийг нягтлан шалгадаг. Дээрх зураг дээр тест хийх шаардлагатай зарим цэгийг харуулсан. “Шатамхай хийн зөвшөөрөгдөх доод хэмжээ” илрүүлэгч багажаар өндөр хэмийн ажил явагдах хэсэг болон халуун оч, хэлтэрхий үсэрч болзошгүй бүх цэгийн эргэн тойронд шалгах хэрэгтэй. Үүнд боловсруулалтын процессын нээлттэй шугам хоолой эсвэл цөөрөм, ус зайлуулах шугам буюу дээр үзүүлсэн зургийн 5-9 цэгтэй адил хэсэгт тестийн багаж (дээжний гуурс) ашиглан тест хийх зэрэг үйлдэл багтана.

Та мэдэх үү?

- Халуун зүсэлт, гагнуур, гриндерээр тасдах ажлын үед үсэрсэн оч маш хол зайд шидэгдэх боломжтой. Тиймээс ихэнх зөвшөөрөл дээр 35 фут (10.7м)-ын зай доторх шатамхай материалыг холдуулах, ноцомхой хийн тест хийхийг шаарддаг.
- Үсэрсэн оч, халуун үртэс таталцлын хүчний нөлөөгөөр доошоо газрын гадарга руу татагддаг ба доор байрлах нүх, хонхорхой руу ч орж болно. Өндөрт хийгдэж буй өндөр хэмийн ажлын доор “шатамхай хийн зөвшөөрөгдөх доод хэмжээ”-г хянах хэрэгтэй.
- Ихэнх төрлийн шатамхай уур нь агаараас хүнд жинтэй байдаг тул бохирын шуудуу, ус цуглуулах нүх зэрэг нам доор газар хуримтлагдах төлөвтэй байдаг.
- Илүү хөнгөн жинтэй шатамхай уур шугам хоолой, хий хадгалах сав, хортой бодис халихаас хамгаалах хашилт зэрэг агааржуулалт муутай хэсэгт байх боломжтой.
- Гэрээт ажилчид, засварын баг танай үйлдвэрлэлийн процессыг сайн мэдэхгүй. Түүнчлэн тэд шатамхай хий байж болзошгүй бүх цэгийг мэдэхгүй байж болно.
- Өндөр хэмийн ажил хийгдэх явцад орчны нөхцөл өөрчлөгдөх боломжтой. Боловсруулалтын процесс, доголдол болон цаг агаарын нөхцөл хүртэл өндөр хэмийн ажил явагдаж буй талбайн ойролцоо шатамхай материал үүсгэж болзошгүй.

Та юу хийж чадах вэ?

- 35 фут (10.7м)-ын бүс, “аюулгүйн хүрээ” эсвэл танай компаниас тусгайлан заасан зай доторх бүх задгай шуудуу, ус цуглуулах нүхийг шалга.
- Орчны нөхцөл өөрчлөгдөх байдлыг хянахын тулд зарим компани “шатамхай хийн зөвшөөрөгдөх доод хэмжээ”-г тогтмол хэмжихийг шаарддаг. Аюулгүй орчин нөхцлийг хангах зорилгоор өртөлтийн талбайг хяна.
- Ноцомхой хий, шатамхай шингэн болон хатуу бодис байж болзошгүй хэсгийн талаар бодохдоо боловсруулалтын процесс явагддаг талбайн тухай мэдлэгээ ашигла.
- Дотоод хэмжилт хийхдээ хий илрүүлэгч багажийг дагалдаж ирдэг “савх” болон дээжний гуурсуудыг ашигла.
- Халуун оч, үртэс үсэрч зөвшөөрөгдөөгүй талбайд нэвтрэхээс сэргийлэхийн тулд гагнуурын бүтээлэг болон бусад хамгаалалтын хэрэгслийг ашигла. ГЭВЧ ЗӨВХӨН ЭДГЭЭРТ БҮРЭН НАЙДАЖ БОЛОХГҮЙ!

Шатамхай хий ноцох боломжтой БҮХ цэгт тест хий!